

“БАГАЧУУД ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /мян.т өг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<p>Зорилго 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.2.10 “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангана.</p>							
<p>Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт–Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө 2.4. Тэгш хүртээмжтэй чанартай боловсрол- Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангаж, дотоод хяналтыг сайжруулна.</p>							
1.1.	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн төрийн өмчийн 74 цэцэрлэг, 13 сургуулиудыг эрүүл ахуйн чанар, стандарт хангасан хүнсний бүтээгдэхүүнээр хангаж ажиллана.	-	Цэцэрлэг, сургуулийн тоо	87	87	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын 74 байгууллага болон ерөнхий боловсролын 16 сургуультай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу эрүүл ахуйн чанар, стандартын шаардлагад нийцсэн 32 нэр төрлийн 131 бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй ханган ажиллаж байна. Монгол Улсын Боловсролын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Хичээл сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх тухай” А/565 дугаар тушаалын хүрээнд 16 сургуулийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүний захиалга тасалдаад байна.	100
1.2.	Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Засгийн газрын 2014 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журмын дагуу Хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалт,	Байгууллагын төсөв 500,0	Хяналт, шалгалт хийсэн тоо	2	4	Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө хуваарийг боловсруулан батлуулж хүнсний бүтээгдэхүүний чанар хадгалалт, түгээлт, албан хэрэг хөтлөлт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 4 үе шаттай дотоод хяналт шалгалтыг зохион байгуулсан. Байгууллагын хуурай хүнс болон махны агуулах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 20 цэцэрлэгийн агуулах бараа бүтээгдэхүүний хадгалалтад хяналт тавьж сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан. Нийт хяналт шалгалтаар 11 алдаа дутагдлыг илрүүлэн цаашид хэрхэн	100

	түгээлтэд хийх дотоод хяналтыг чанаржуулна.					сайжруулах талаар зөвлөмж бэлтгэн хүргүүлж зөрчлийг арилгуулсан.	
1.3.	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна, хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Байгууллагын 2024-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	60
Зорилт 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт- Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө 2025 оны төлөвлөгөө 3.1. Санхүү төсвийн зохицуулалт-228 Нийслэлийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлнэ. Нийслэлийн Засаг даргын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөр 4.1.4 Ойжуулах, ойн тэлэлт, ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, хамгаалах, замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ.							
2.1	УИХ, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамж, дээд газрын үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллана.	-	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн хувь	100	100	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай" 01 дүгээр, "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 дугаар, "Засгийн газраас авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавруудын хэрэгжилтийг 2. Нийслэлийн засаг даргын 2025 оны А/62 дугаар захирамж зэргийн биелэлтийг сар бүрийн 25-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна. 3. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган, заасан хугацаанд нь хүргүүлж ажилласан. 	100
2.2	Байгууллагын 2025 оны эдийн засгийн зорилтод түвшинг ханган, ашигтай ажиллагааг нэмэгдүүлэх	-	Төлөвлөсөн ашгийн биелэлтийн хувь	100	100	2025 оны зорилтот түвшингээр 8.669.696.02 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 4,869,322.76 мянган төгрөгийн орлого олж, төлөвлөгөөний биелэлт 57 хувьтай байна. Өмнөх оноос 3,5 хувиар өсөлттэй байна.	40
2.3	Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хамгаалж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг зохион байгуулах	-	Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийн тоо	2	2	2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг захирлын тушаалын дагуу тооллогын комисс тоолж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.	80
2.4	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, үргүй зардлыг хэмнэнэ.	-	Санхүүгийн сахилга батын хэрэгжилтийн хувь	100	100	2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 2025 оны төсөвлөсөн бүх зардлуудыг хэмнэж ажилласан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Цалингийн зардлыг 259,919.50 мянган төгрөгөөр 	100

						<ul style="list-style-type: none"> • Гэрэл цахилгааны зардлыг 60,036.11 мянган төгрөгөөр • Бичиг хэргийн зардал 5,126.11 мянган төгрөг • Шатахууны зардал 9,505.14 мянган төгрөгөөр тус тус хэмнэн ажиллалаа. • Албан томилолтын зардал гараагүй. • Шагнал урамшуулалын зардал 3,750.00 мянган төгрөгөөр тус тус хэмнэн ажиллалаа. 	
2.5	Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох заавар, журмын дагуу хөтөлж, тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Архив, албан хэрэг хөтлөлтийн холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу хөтөлж, тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гарган удирдлагад танилцуулж ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нийт 150 албан бичиг ирснээс хугацаатай 45, хугацаагүй 105 албан бичиг ирж шийдвэрлэснээс хугацаа хоцорч шийдвэрлэсэн албан бичиг байхгүй. Байгууллагын хэмжээнд нийт 169 албан бичиг явуулснаас хугацаатай 3, хугацаагүй 166 албан бичгийг цаг алдалгүй крилл болон үндэсний хос бичгээр хүргүүлэн ажилласан.	100
2.6	2024 оны архивын баримтуудыг хууль, журмын дагуу 2025 оны эхний улиралд багтаан ажилтнуудаас бүрдлийг хангуулан хүлээн авч, "Байнга", "Түр", "70 жил"-ээр ангилан данс бүртгэл үүсгэж, төрөлжүүлэн бүртгэнэ.	Байгууллагын төсөв 3,500.0	Архивын нөхөн бүрдүүлэлтийн хувь	100	100	Байгууллагын архивт батлагдсан хуваарийн дагуу 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ажилчдаас 2024 онд үүсэж хөтлөгдсөн баримтыг хүлээн авч байнгын 22 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 4 хадгаламжийн нэгж, түр хадгалах 67 хадгаламжийн нэгжийг хүлээн авч байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтийн хийсэн. 2025 оны Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэн байгууллагын архивт баримтын гэнэтийн тооллого хийн, 195 хадгаламжийн нэгжийн баримтын хавтас солих, байнга 68 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 67 хадгаламжийн нэгж, түр хадгалах 653 хадгаламжийн нэгж, нийт 788 хадгаламжийн нэгжийг хайрцаглах ажлыг зохион байгуулж ажилласан.	100
2.7	"Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг	Байгууллагын төсөв 200,0	Хэвлэмэл хуудас захиалсан тоо	-	900	"Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022" стандартад зааснаар хэвлэмэл хуудсыг хэвлүүлж, 2025 оны 12 дугаар сарын 03-ны байдлаар захирлын үйл ажиллагааны чиглэлээр гаргасан 25 тушаал, хүний	100

	захиалах, албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөж хэвших					нөөцийн чиглэлээр гаргасан 22 тушаал нийт 47 тушаалыг, 165 албан бичиг явуулснаас 155 албан бичгийг монгол бичигт хөрвүүлэн албан хэргийг крилл болон хос бичгээр хөтлөн ажилласан.	
2.8	Албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлнэ.	Байгуулагын төсөв 1,000.0	Сургалт зохион байгуулсан тоо	-	2-оос баггүй	Нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн Монгол, хэл бичгийн багш Н.Жанчивтай гэрээ байгуулан албан хаагчдын монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэхээр 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 2 сарын сургалт зохион байгуулж, сургалтын үр дүнд байгууллагын ажилчдын монгол бичгийн ур чадвар нэмэгдэн бичиг баримтыг монгол бичгээр боловсруулах, явуулах, Mongolian Baiti программ дээр шивж бичих, монгол бичиг ашиглах чадвар нэмэгдсэн.	100
2.9	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллах	-	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	100	100	2025 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуй нэгж хуулийн этгээдээс, ажилтан, албан хаагчдын харилцаа хандлага болог байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, санал, хүсэлт байхгүй болно. Тайлант хугацаанд нийслэлийн өргөдөл гомдлын цахим erp.ulaanbaatar.mn программаар ирсэн 6 өргөдлийг хүлээн авч ажилд орох 2, ажил хавсран гүйцэтгэх 1, ажлаас чөлөөлөх 3, өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	100
2.10	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг Хөдөлмөрийн аюулгүй байдалд хяналт тавих, аюулаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөр хамгааллын хувцас, ажлын хувцас хэрэгслээр хангана.	Байгуулагын төсөв 1,700.0	тоо	2	2	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм чанар зохистой хэрэглээнд хяналт тавин үйлчлэгчийн өмд, цамцны хос хувцасыг шинээр олгож, түгээлтийн болон оффисын ажилчдад маск, гар ариутгагч, 540 ширхэг ажлын бээлийгээр бүрэн ханган, түгээлтийн 7 ажилтны хавар, намрын гутлыг шинээр олгон ажиллаж байна.	100
2.11	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж, ялгаварлан гадуурхал гаргалгүй ажиллана.	-	Жендерийн асуудлаар гарсан зөрчлийн тоо	0	0	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэн "Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдье" уриатай "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-д 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл нэгдэн постер бэлтгэн ERP систем болон байгууллагын www.bagachuudkhuns.ub.gov.mn -д сайтад ялгаварлан гадуурхал гаргалгүй ажиллахыг уриалж олон нийтэд түгээж ажиллалаа.	100

2.12	Сул ажлын байрны зарыг өөрийн цахим хуудаст тогтмол байршуулж, сонгон шалгаруулалтыг явуулж байх;	-	Сул ажлын байрыг зарласан тоо	3	3	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгууллагын бүтэц орон тооны дутагдалтай 2 сул орон тоог байгууллагын цахим хуудас www.bagachuudkhuns.ub.gov.mn -д болон фэйсбүүк хуудсанд нийтэлж хоол зүйч, жолоочийн үүрэгт ажилд сонгон шалгаруулж томилсон. Хүүхэд харах чөлөөтэй байсан эрүүл ахуйчийг ажилд нь буцаан томилсон.	100
2.13	Байгууллагын албан хаагчдын 2025 оны сургалтын төлөвлөгөө болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг хангана.	Байгууллагын төсөв 15,000.0	Хэрэгжилтийн хувь	100	100	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан дараах сургалтуудад хамрагдлаа. 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр “Албан хэргийг хос бичгээр хөтлөх, архивын нэгж бүрдүүлэх” сургалтанд захирал Б.Мөнхнасан, менежер, хүний нөөц Г.Отгонцэцэг, ерөнхий нягтлан бодогч А.Нямжав, тооцооны нягтлан бодогч Г.Нансалмаа, ХАБЭА, дотоод хяналтын ажилтан Д.Дашцэрэн, архив бичиг хэргийн ажилтан П.Намжилмаа, эрүүл ахуйч Д.Мөнхцэцэг, хоол зүйч О.Болорчимэг, 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр “Эрүүл хүн-Эрүүл хүнс” хүнсний чанар аюулгүй байдлын нөлөөллийн аян сургалтанд эрүүл ахуйч Д.Мөнхцэцэг, хоол зүйч О.Болорчимэг, 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй” сургалтанд менежер, хүний нөөц Г.Отгонцэцэг, ерөнхий нягтлан бодогч А.Нямжав, 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хотын хөгжлийн чиг хандлага “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн сургалтанд менежер, хүний нөөц Г.Отгонцэцэг, архив бичиг хэргийн ажилтан П.Намжилмаа, 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр “Монгол бичгийн цахим бичвэр” сургалтанд менежер, хүний нөөц Г.Отгонцэцэг, архив бичиг хэргийн ажилтан П.Намжилмаа, 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны улсын үзлэг сургалтанд менежер, хүний нөөц Г.Отгонцэцэг, архив бичиг хэргийн ажилтан П.Намжилмаа нар, 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн HR-2025 сургалт, уулзалтанд	100

					<p>менеджер, хүний нөөц Г.Отгонцэцэг, архивын улсын үзлэгтэй холбогдуулан архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалтад нийт ажилтнуудыг, 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Төрийн болон нийслэлийн өмчит хуулийн этгээдэд төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх сургалтад А.Нямжав, Г.Нансалмаа нар, Нийслэлийн албан хаагчдыг чадавхижуулах хэлэлцүүлэг, арга хэмжээнд 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Б.Мөнхнасан, Д.Дашцэрэн нар нийт 10 удаагийн сургалтад нийт давхардсан тоогоор 17 ажилтан хамрагдсан. Сургалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу 2025 оны 01 дүгээр сарын 23-наас 10 дугаар сарын 16-ны өдрийн хооронд цэцэрлэг, сургуулийн эрхлэгч, захирал, нярав, тогооч нарт “Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичгийн тухай ойлголт, бараа бүтээгдэхүүний онцлог”, “Эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх”, “Албан хэрэг хөтлөлт, архив бичиг хэргийн талаар”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар”, “Хүнсний аюулгүй байдлын тухай”, “Ариутгал болон цэвэрлэгээ үйлчилгээний талаар” “Агуулахын стандартын талаар”, “Хүнсний нэмэлтийн тухай”, “Стресс менежмент” гэсэн 9 сургалтыг нийт ажилчдад зохион байгуулсан. Нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн Монгол, хэл бичгийн багш Н.Жанчиваар алба хаагчдын монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэхээр 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийг дуустал сургалт зохион байгуулж ажилласан. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг 01 дүгээр сарын 02-ны өдөр батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Өмчийн харилцааны газарт 02 дугаар сарын 17-ны өдөр 2025 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлуулахаар саналыг хүргүүлсэн. 2025 оны зорилтот</p>
--	--	--	--	--	---

					<p>түвшин батлагдсанаар ажилчдын албан тушаалын цалинг 20 хувиар нэмж, хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.6-д заасны дагуу хоол, унааны мөнгийг өдрийн 24,000.00 төгрөг болгож ажиллалаа. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаалаар “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам” Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хүрээнд Дөрөвдүгээр эмнэлэгтэй 01 дүгээр сарын 20-ны өдөр гэрээ байгуулан 17 ажилчид эрт илрүүлгийн 29 төрлийн үзлэг шинжилгээнд хамрагдаж нийт 8,750,000.00 төгрөгийг зарцуулсан. Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвтэй 01 дүгээр сарын 02-ны өдөр гэрээ байгуулан 17 ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2 удаа хамруулахад нийт 1,550,000.00 төгрөг зарцуулсан. Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.14-т заасны дагуу Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнуулсан 2 ажилтанд тус бүр 1,000,000.00 төгрөг, нийт 2,000,000.00 төгрөг, 8 дугаар зүйлийн 8.3-т заасны дагуу хурим хийсэн 1 ажилтанд 1,000,000.00 төгрөг, 8.11.2-т заасны дагуу 1 ажилтан Отгонтэнгэр их сургуулийн эрх зүйн ангид 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн эрх зүйчээр суралцаж байгаа тул сургалтын төлбөрийн 30 хувь болох 1,155,000 төгрөг, 8.12-т заасны дагуу ар гэрийн гачигдал гарсан 5 ажилтан тус бүр 1,000,000 төгрөг, нийт 5,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Сар шинийн баярыг тохиолдуулан 4 ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж 600,000 төгрөг, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилчдын 29 хүүхдэд гарын бэлэг өгч, нийт 1,740,000 төгрөг, ахмадын баярыг тохиолдуулан 4 ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж 600,000.00 төгрөгийг зарцуулж ажилласан.</p>
--	--	--	--	--	---

2.14	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжилт ийн хувь	-	100	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг нийт ажилчдад зохион байгуулсан.	100
2.15	“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Байгуу лагы н төсөв 500,0	Хэрэгжилт ийн хувь	-	100	Байгууллагын хамт олны саналын дагуу “Ёс зүйн дэд хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэй 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгуулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний дагуу “Ойлголцохуйд суралцахуй 9 сургалт 4 өдөрлөг”, “Авилга, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтыг нийт ажилчдад зохион байгуулсан. Тайлант хугацаанд сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан 1 ажилтанд 9 дүгээр сарын 16-ны өдрийн Б/17 тоот тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан болно.	100
2.16	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд дээд газар албан тушаалтнаас ирүүлсэн чиглэлийн дагуу мод тарих арга хэмжээг зохион байгуулна.	Байгуу лагы н төсөв 300,0	Арга хэмжээ зохион байгуулсан тоо	2	2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд хуваарийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Ар гүнт “Инчон мөрөөдлийн төгөл”-д урд нь тарьсан 257 ширхэг шинэс модны арчилгаа, усалгаанд анхаарч, арчлан ажилласан.	100
Зорилт 3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт- Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан, баталгаатай, чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангана. (НИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар дүрэм батлагдсан)							
3.1	2025 онд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгжүүдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулж, гэрээ байгуулна. Тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, tender.gov.mn сайтаар нийтэд ил тод зарлан, зохион байгуулна.	-	Багцын тоо	22	28	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 2025 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 33 багц ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиудад хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлахад 23 багцад 16 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн	100

					<p>бөгөөд 10 багцад огт тендерийн материал ирээгүй бөгөөд 23 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 6 аж ахуйн нэгж байгууллагын 13 багцад гэрээ байгуулах эрх олгож, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, төсөвт өртөг хэтэрсэн, нэг ч оролцогч оролцоогүй 20 багцад дахин нээлттэй тендер шалгаруулалтыг зарлан, 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нээлтээ хийхэд 7 багцад 5 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 13 багцад огт тендерийн материал ирээгүй бөгөөд 7 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 3 аж ахуйн нэгж байгууллагын 5 багцад гэрээ байгуулах эрх олгож, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, төсөвт өртөг хэтэрсэн, нэг ч оролцогч оролцоогүй 15 багцад дахин нээлттэй тендер шалгаруулалтыг 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр зарлаж, 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр нээлтэй хийхэд 3 багцад 2 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 12 багцад огт тендерийн материал ирээгүй бөгөөд 3 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 2 аж ахуйн нэгж байгууллагын 3 багцад гэрээ байгуулах эрх олгож, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, төсөвт өртөг хэтэрсэн, нэг ч оролцогч оролцоогүй 12 багцад 09 дүгээр сарын 08-ны өдөр дахин нээлттэй тендер шалгаруулалтыг зарлан, 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр нээлтээ хийхэд 8 багцад 2 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 4 багцад огт тендерийн материал ирээгүй бөгөөд 8 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 1 аж ахуйн нэгж байгууллагын 7 багцад гэрээ байгуулах эрх олгож, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, нэг ч оролцогч оролцоогүй 5 багц байна. Тендерийн баримт бичгийг хянан, тендер хүлээн авч байгаа ба ил тод байдал, чанар, хугацаа, олон нийтийн оролцоонд тулгуурласан хяналтыг сайжруулан, холбогдох</p>	
--	--	--	--	--	--	--

						хууль тогтоомжийг баримтлан ажиллаж байна. Түргэн гэмтэх бүтээгдэхүүн болох сүү, талх, нарийн боовыг худалдах худалдан авах гэрээний дагуу “Апу дэйри” ХХК, “Талх чихэр” ХХК, “Прайм пастри” ХХК, гурвалсан гэрээгээр шууд түгээлгэж, хөндлөнгийн хяналтыг хийн ажиллаж байна.	
3.2	Шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулан, шаардлагатай барааг Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.6 дугаарт зааснаар бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас ирж буй хүнсний бүтээгдэхүүн тус бүрийн итгэмжлэгдсэн лабораторын сорилын дүн, аюулгүй үзүүлэлт бүрэн шинжилгээний бичгийг эх хувиар нь, гарал үүслийн гэрчилгээтэй, шаардлагатай тохиолдолд импортын бүтээгдэхүүний гаалын мэдүүлгийн гэрчилгээтэй эсэхийг шалган үндэслэн татан авч, стандарт, шаардлагад нийцсэн агуулахад горимын дагуу хадгална.	-	Барааны нэр төрлийн тоо	110	120	“Эрдэнэ энх трейд” ХХК, “Хүрэмт халуун рашаан” ХХК “Буянт бумба эрдэнэ” ХХК, “ЧЦАГ” ХХК, “Шинэ амттан” ХХК, “Грийн дистрибьюшн” ХХК, “Агро трейд” ХХК, “Баясах-Өргөө трейд” ХХК зэрэг 8 аж ахуйн нэгж байгууллагад гэрээ байгуулах эрх олгосны дагуу агуулах болон бараа бүтээгдэхүүний нөөц, хадгалалт, хамгаалалтыг үзэхэд бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын агуулах стандартын дагуу нөөц боломж сайтай байсан бөгөөд итгэмжлэгдсэн лабораторын сорилын дүн, аюулгүй үзүүлэлт бүрэн, шинжилгээний бичгийг эх хувиар нь, гарал үүслийн гэрчилгээтэй, шаардлагатай тохиолдолд импортын бүтээгдэхүүний гаалийн мэдүүлгийн гэрчилгээтэй эсэхийг шалган үндэслэн татан авч, стандарт, шаардлагад нийцсэн агуулахад горимын дагуу хадгалан хяналт тавин ажилласан.	100
3.3	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй биечлэн ажилладаг ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд жилд 2 удаа хамруулна.	Байгуулагын төсөв 2,192.0	Нийт ажилчдын тоо	20	20	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын дагуу Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвтэй 01 дүгээр сарын 02-ны өдөр гэрээ байгуулан 17 ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 02 дугаар сарын 19, 08 дугаар сарын 20-ны өдрүүдэд хамруулахад нийт 1,550,000.00 төгрөг зарцуулсан.	100
3.4	Байгууллагын нийт ажилчдыг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээ, оношлогоонд бүрэн хамруулж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.	Байгуулагын төсөв 10,000.0	Эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо	18	18	Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаалаар “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам” Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хүрээнд Дөрөвдүгээр эмнэлэгтэй 01 дүгээр сарын 20-ны өдөр гэрээ байгуулан 17 ажилчид эрт илрүүлгийн 29 төрлийн үзлэг шинжилгээнд хамрагдаж нийт 8,750,000.00 төгрөгийг зарцуулсан.	100

3.5	Байгууллагын контор, махны болон хуурай хүнсний агуулахууд, хүнсний зориулалттай түгээлтийн автомашинуудыг ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг зохионо.	Байгууллагын төсөв 6,632.7	Ариутгал хийгдсэн тоо	3	4	“САН ХИМИ” ХХК-тай 03 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулан 03 дугаар сарын 31, 08 дугаар сарын 19-ний өдрүүдэд байгууллагын контор болон хуурай хүнсний-7, хөргүүртэй агуулахад шавжгүйтэл, мэргэч, халдваргүйжүүлэлт, түгээлтийн автомашинд ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэсэн бөгөөд хуурай хүнсний-7 агуулахад долоо хоног бүрийн даваа, пүрэв, баасан гарагт, хөргүүртэй 1 агуулахад долоо хоног бүрийн мягмар, лхагва гарагт тогтмол хуурай болон чийгтэй цэвэрлэгээ хийж эрүүл ахуйчаар хянуулан, бүртгэл хөтлөн ажиллаж байна.	100
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд-Байгууллагын бусад үйл ажиллагаа, үйлчилгээг нээлттэй, шуурхай үзүүлж ажиллана.							
4.1	Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр явуулж, иргэд, олон нийтийн оролцоо, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд оруулж, хэрэгжилтийг ханган, хяналтыг сайжруулах;	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 2025 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 33 багц ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хүнсний бараа, бүтээгдэхүүн худалдан авалтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг нийт 4 удаа зохион байгуулж, 28 багцад 8 аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар шилэн данс сайтад нийт 157 мэдээлэл байршуулахаас 1-ээс 12 дугаар саруудад 140 мэдээллийг хугацаанд нь мэдээллэсэн бөгөөд үлдсэн 17 мэдээлэл хугацаа нь болоогүй бөгөөд үүнээс 5,000,000.00 төгрөгөөс дээш нийт 4,292,414.8 мянган төгрөгийг орлогыг, нийт 3,328,097.73 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан тухай бүр нь холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж тайлагнан ажилласан.	100
4.2	Байгууллагын цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан иргэд олон нийтэд ил тод мэдээлж цахим хуудсанд шинэчлэл сайжруулалт хийх;	Байгууллагын төсөв 15,000.0	Мэдээллийн тоо	12	12	Байгууллагын цахим хаяг Bagachuudhuns.ub.gov.mn-32, Shilen.gov.mn-77 үзүүлэлтийн дагуу нийт 109 мэдээ, мэдээлэл, Shilendans.gov.mn сайтад 2025 онд нийт 157 мэдээлэл нийтлэхээс 1-ээс 12 дугаар саруудад 140 мэдээллийг хугацаанд нь мэдээллэсэн бөгөөд үлдсэн 17 мэдээлэл хугацаа нь болоогүй бөгөөд үүнээс 5,000,000.00 төгрөгөөс дээш нийт 4,292,414.8 мянган төгрөгийг орлогыг, нийт 3,328,097.73 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ	100

						гарсан тухай бүр нь холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж тайлагнасан. Байгууллагын мэдээллийн самбарт санхүү, хүний нөөц, ажлын зар, дүрэм журам, сургалтын мэдээлэл, шинэ мэдээлэл, үйл явцыг тухай бүр нь оруулан ажиллаж байна.	
4.3	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах;	Байгууллагын төсөв 500,0	Судалгааны тоо	2	2	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа зохион байгуулж, судалгааны дүгнэлтэд үндэслэн бараа бүтээгдэхүүний төрлийг нэмж, түгээлтийн багийн ажилчдад 2 удаагийн сургалт зохион байгуулж, тухай бүр сайжруулан ажиллаж байна.	100
4.4	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн төрийн өмчийн цэцэрлэг, сургуулиудад нийлүүлэх хүнсний бараа, бүтээгдэхүүний онлайн захиалгыг боловсронгуй болгож, захиалгын тоог нэмэгдүүлэх;	-	7 хоногийн захиалгын тоо	2	2	Тус байгууллагын вэйб сайтын шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан онлайн захиалга хийгдээгүй болно.	
4.5	MNS ISO 9001:2016 – чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх;	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Тус байгууллага нь MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг 2026 онд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	
4.6	Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлэх;	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг 2026 онд хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	
4.7	Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх;	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг 2026 онд хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	
4.8	Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлэх;	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг 2026 онд хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	
Зорилт 5. “Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд- Орчны тохижилтыг сайжруулж бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлж ажиллана.							
5.1	Байгууллагын хашааны дотор талын тодорхой хэсгийг стандартад нийцүүлж цементлэх	Байгууллагын төсөв 50,000.0	Хэрэгжилтийн хувь	-	100	Байгууллагын объектын дээврийн хэсэг газрыг лагдаж, зориулалтын будгаар будаж, хашааны хаалга, гадна хайсыг будаж шинэчлэн засварлаж ажилласан. “ЭН ӨҮ ТИ ЭС” ХХК-тай гэрээ байгуулан байгууллагын хашааны дотор талын тодорхой хэсгийг стандартад нийцүүлж цементлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.	100

Зорилт 6. Хотын хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд-Ханган нийлүүлдэг хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангаж, харилцагч цэцэрлэг, сургуулиудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллана.							
6.1	Хотын хөгжлийн индекс: 30 (Хүнсний хангамжийн чанар) Нийлүүлж буй 32 нэр төрлийн 119 бараа бүтээгдэхүүн түүхий эд бүрийг шинжилгээнд хамруулж ажиллана. Лабораторийн сорилтын тогтоосон цаг тухай бүрт нь хамруулж ажиллана.	-	I, II, IV улиралд шинжилгээнд хамруулсан бүтээгдэхүүний тоо	0	3	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас хүлээн авч буй 32 нэр төрлийн 119 бараа бүтээгдэхүүнийг чанар, стандартын шаардлагад нийцсэн, итгэмжлэгдсэн лабораторын сорилын дүн болон шинжилгээний аюулгүйн үзүүлэлт бүрэн хамрагдсан, шинжилгээний бичигтэй хүнсний бүтээгдэхүүнийг Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиудад нийлүүлдэг. Мах, махан бүтээгдэхүүнийг мал эмнэлгийн нэгдсэн системд нэвтэрч, мал эмнэлгийн гэрчилгээ, гарал үүсэлийн бичгийг, хүнсний ногооны гарал үүсэлийн бичгийг 7 хоног бүр, лабораторийн шинжилгээний бичгийг сар бүр, хадгалах нөхцөл урт бүтээгдэхүүний шинжилгээний бичгийг 3 сараас 1 жил хүртэл, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт Монгол Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага хангасан байна" гэж заасны дагуу импортоор орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг импортын гэрчилгээ болон гаалийн мэдүүлгийг үндэслэн хүлээн авч байна. Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиудад хүнсний бараа бүтээгдэхүүний шинжилгээний бичгийг цахимаар цаг тухай бүрт нь илгээн хамтран ажилласан.	100
6.2	Хотын хөгжлийн индекс: 52 (Хүнсний хангамжийн хүртээмж) Цэцэрлэг, сургуулиудад хүнсний бүтээгдэхүүний татан авалт, хадгалалт хамгаалалт, түүний боловсруулалтад эрүүл ахуйн талаарх зөвлөн туслах үйлчилгээ, хоол зүй, шим тэжээлийн арга зүйн зөвлөгөөг очиж үзүүлнэ. Илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах ажлыг зохион байгуулна.	Байгууллагын төсөв 500,0	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх цэцэрлэг сургуулийн тоо	0	14	Чингэлтэй, Сүхбаатарт дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиудаас 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 38 санал, гомдол ирсэн. Үүнээс Сүхбаатар дүүргийн 13, Чингэлтэй дүүргийн 25 сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиудаас ирсэн санал, гомдлыг тухай бүрт нь хүлээн авч буцаан татан авалт хийж, нийлүүлэгч аж ахуй нэгж рүү буцааж, түргэн шуурхай шийдвэрлүүлэн ажилласан. Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиас төмс, хүнсний ногоонууд муу байна гэсэн гомдлын дагуу "Эрдэнэ энх трейд" ХХК-ны ногооны агуулахад 2 удаа очиж	100

					ажиллаж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, барааны чанарыг сайжруулан чанар, стандартад нийцсэн бараагаар ханган ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ:

Х.НЯМБААТАР

2025 оны сарын өдөр

ТАЙЛАГНАСАН:

БАГАЧУУД ХҮНС ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Б.МӨНХНАСАН

2025 оны *12* сарын *03* өдөр

